

**Монгол улсын анхны сэтгүүл “Шинэ толь”-д
нийтлэгдсэн /монгол үсгээр/ гадаад улсын
нэрийн үсэг зүйн судалгаа**

Н. Балжинням (МУИС)

Монгол улсын шинжлэх ухаан, танин мэдэхүйн анхны сэтгүүл болох “Шинэ толь” (Монгол улсын 26 дугаар он. 1-2 сар. № 2.) хэмээх сэтгүүлд нийтлэгдсэн дэлхийн газрын зураг дахь олон улсын нэр нь европын хэлнээс манай бичгийн мэргэдийн монгол үсгээр анх буулгасан европын хэлний үгс учраас монгол бичгийн хэлний ормол үгийн судалгаанд зайлшгүй хамааралтай зүйл хэмээн үзэж, түүнд латин галиг, орос, англи нэрийг нэмэн, холбогдох үсэг зүйн судалгааны хамт уншигч олноо толилуулж байна.

ᠠᠪᠢᠰᠢᠨᠢ - **Abissini** - **Абиссиния** - **Abyssinia**. Өнөөдрийн **Этиоп** (Оросоор **Эфиопия**) улсыг ийнхүү нэрлэж байжээ. Нэрийн бичлэгийн уламжлал өнөөдрийн тогтсон бичлэгээс зөрөхгүй байгаа юм. Толь бичгүүдэд бичлэгийн энэ хувилбар байна. Гадаад үгийн дараалсан гийгүүлэгч үсгүүдийг ийнхүү хэвээр нь бичиж ирсэн нь тухайн үгийн хэлбэрийг хадгалахад анхаарч байсны гэрч болж байна. Одоо ч энэ зарчим хэвээр байна.

ᠠᠶᠤᠨᠢᠰᠠᠩ - **Avyanistang** - **Афганистан** - **Afghanistan**. Энэ үгийг монгол үсгээр бичсэн байдлыг тодруулбал; “Монгол үсгийн дүрмийн толь”- д **ᠠᠶᠤᠨᠢᠰᠠᠩ** - **Avyanistang** (48-р тал), “Монгол бичгийн хадмал толь”- д **ᠠᠶᠤᠨᠢᠰᠠᠨ** - **Afyanistan** (487-р тал), VIII ангийн “Монгол бичиг”-ийн сурах бичигт **ᠠᠶᠤᠨᠢᠰᠠᠨ** - **Afgenistan, Afyanistan** (111 - р тал) зэрэг хувилбараар бичсэн нь тухайн үгний бичлэг нэг мөр болж тогтоогүйг гэрчилж байна. Өнөөдөр энэ үгийг заавал тогтсон уламжлалын дагуу бичих хэрэгтэй хэмээн үзэх нь хэтэрхий нэг талыг баримтласан болох тул сүүлчийн хувилбараар бичих нь үсгийн дүрмээс гажсан зүйл байхгүй учраас **ᠠᠶᠤᠨᠢᠰᠠᠨ** - **Afyanistan** - **Афганистан** хэмээн бичих нь зүйтэй. Гадаад үгийг монгол үсгээр бичиж байсан эхний үед Дундад Азийн улсуудын нэрийг **ᠠᠶᠤᠨᠢᠰᠠᠨ**, **ᠠᠶᠤᠨᠢᠰᠠᠨ**, **ᠠᠶᠤᠨᠢᠰᠠᠨ**.

ᠠᠵᠤᠰᠤᠳᠠᠩ · ᠠᠵᠤᠰᠤᠳᠠᠩ - Kazaystang, Kirgistang, Uzbekstang, Turkmenstang, Tajiystang хэмээн бичиж байсан төдийгүй манай улсыг ~~ᠮᠣᠩᠭᠣᠯᠤᠰᠤᠳᠠᠩ~~ – **Mongolstang** хэмээн бичсэн хувилбар ч байдаг. Энэ нь англи зэрэг хэлний –land, орос хэлний улс, орны нэрийн –ия дагавар, турк хэлний –стан зэрэг нь даруй монгол хэлний “улс” хэмээх үгтэй утгаараа бүрэн дүйдгийг харуулж байна.

ᠠᠩᠭᠣᠯᠠ · ᠠᠩᠭᠣᠯᠠ - **Angyola, Anggola - Ангола - Angola.** Энэ нэрийг монгол үсгээр буулгахдаа дээрхи хоёр хувилбараар бичиж ирсэн байна. Гэвч монгол үсгээр европын хэлний үгийг бичиж ирсэн уламжлалаас үзэхэд дээрх хоёр хувилбарын ~~ᠠᠩᠭᠣᠯᠠ~~ - **Angyola** нь бичигт хэвшсэн байна. Монгол бичгийн хэлэнд нэгэнт ᠶᠣ · ᠶᠣ · ᠶᠣ - **yo, - yo, - yo** хэмээх үет үсгүүд байгаа учир тэдгээрийг гадаад үгэнд хэвээр нь авч хэрэглэхэд харшлах зүйл байхгүй. Харин - **yo, - yo, - yo** үеүдийг ᠙ · ᠙ · ᠙ хэмээх хэвт үсэг болгон гадаад үгэнд хэрэглэх нь бусад ийм төрлийн үсгүүдтэй хутган андуурч болзошгүй юм.

ᠠᠩᠭᠯᠢ - **Anggli - Англия - England.** Энэ нэрийн бичлэгийн хэлбэр тогтсон гэж үзэж болно. Ардын хувьсгалын эхин үед гарч байсан ном, сонин, хэвлэлд ~~ᠠᠩᠭᠯᠢ~~ - **Anggeli** гэж бичдэг хувилбар бас байжээ.

ᠠᠮᠢᠷᠢᠬᠢ - **Amerika - Америка - America.** Энэ үгийн бичлэгийн өөр нэг хувилбар нь 1925 оны 9-р сарын 4-ний “Үнэн” сонинд ~~ᠠᠮᠢᠷᠢᠬᠢ~~ ᠠ – **Amirih-a – Амирих-а** хэмээн бичсэн байна. Мөн ~~ᠠᠮᠢᠷᠢᠬᠢ~~ - **Amirig - Амириг** гэж бичсэн тохиолдол ч бий. Энэ үгийг ~~ᠠᠮᠢᠷᠢᠬᠢ~~ – **Amerika** хэмээн толь бичгүүдэд бичиж хэвшсэний дагуу өнөөдөр бичиж байна.

ᠠᠷᠠᠪᠢ - **Arab - Аравия - Arabia.** Нэрийг уруулын, шүргэх, дуутай “**ᠰ** – **v(w)**” - **в**” гийгүүлэгчээр бус, уруулын, хамжих, дуутай “**ᠪ**” - **б**” гийгүүлэгчээр төгсгөсөн нь нэлээд сонин юм. Орос хэлэнд нэр үгийн хэлбэр нь “Аравия”, тэмдэг үгийнх нь “арабский” гэсэн хэлбэртэй юм. Харин англи нэрийн “Arabia” хэмээх бичлэг нь ~~ᠠᠷᠠᠪᠢ~~ – **Arab** гэсэн бичлэг болон тогтжээ. Мөн гадаад нэрийг монгол үсгээр бичиж байсан эхний үед монгол уншигчдад хялбар болгох үүднээс энэ “**ᠰ** – **v(w)**” орох газар “**ᠪ**” - **б**” гийгүүлэгчийг бичиж байжээ. Б. Я. Владимирцов бүтээлдээ энэ нэрийг товчлохдоо “**араб.**” хэмээн бичсэн нь олонтаа тааралдана.(Владимирцов-205). Энэ үгийн бичлэгийн өөр хувилбар байхгүй.

ᠠᠹᠢᠷᠢᠭᠢ · ᠠᠹᠢᠷᠢᠭᠢ - **Africa - Африка - Africa.** Энэ үгийг “**Франц ба Европ газрын түүх**” - ийн 1-р дэвтэрт ~~ᠠᠹᠢᠷᠢᠭᠢ~~ - **Afrig – Африг**, зарим нэг сонин хэвлэлд ~~ᠠᠹᠢᠷᠢᠭᠢ~~ - **Afriy** хэмээн бичсэн бий. Монгол үсгээр гадаад үгийг бичихдээ төгсгөлийн “**ᠶ**” - **к**” гийгүүлэгчийг түүнд орох эгшиг үсгүүдийн байдлаас хамааруулан тэрхүү “**ᠶ**” - **к**” гийгүүлэгчийн оронд **агшилга, эгшилгэ** хоёрын аль нэгийг бичих дүрэм бас бий. Харин

сүүлийн үеийн толь бичиг, сурах бичиг зэрэгт **ᠠᠶᠢᠷᠢᠴᠢ** - **Africa-Африка** хувилбараар бичиж хэвшжээ.

ᠪᠡᠯᠭᠢ - **Belgi - Бельгия - Belgium**. Орос хэлэнд "л - l - 3 . 7 . 7 " гийгүүлэгч урьд, хойноо орсон бусад гийгүүлэгчийг зөөлрүүлнэ. Тийм учраас "л-l" гийгүүлэгчийн дараа "ь" зөөлний тэмдэг бичнэ. Харин монгол бичгийн хэлэнд энэ мэтийн үгийг буулгахдаа зөөлрүүлж "и - l - ᠨ . ᠷ" нэмэж бичих шаардлагагүй, харин тэр нь аяндаа зөөлөрч хэлэгдэнэ. Ийм үзэгдэл европын бусад хэлэнд ч байна.

ᠭᠡᠮᠠᠨᠢ - **Germani - Германия - Germany**. Энэ үгийг сүүлийн үед монгол хэлний шинэ үсгийн дүрэмд ойртуулан бичих болсон байна. Жишээ нь: Намын 11-р их хурлын тайлан илтгэлд одоогийн кирил бичгийг дагуулан **ᠭᠡᠮᠠᠨ** - **German - Герман** хэмээн бичжээ. Академич Б. Ринчений бичсэн "Үгийн утга, учир" номонд энэ үгийг **ᠭᠡᠮᠠᠨᠢ** - **Germani - Германи** хэмээн бичих нь зүйтэй гэсэн байна. Гэхдээ сүүлийн үеийн толь бичиг болон бусад ном, зохиолд **ᠭᠡᠮᠠᠨ** - **German - Герман** гэсэн хэлбэрээр бичиж хэвшсэн байна.

ᠶᠡᠨ - **Iran - Иран - Iran**. Нэрийн бичлэг нь энд байгаа хэлбэрээр хэвшжээ. Харин Академич Б. Ринчений бичсэн "Үгийн утга, учир" номонд энэ үгийг **ᠶᠡᠨᠭ** - **Irang - Иран** хэмээжээ. Дуудах байдлаас нь үзсэн ч гэсэн адагт их энхлиг байгаа нь илт ажиглагдана. **ᠶᠡᠨ** хэмээн бичих нь монгол хэлний **ирэн, очин** гэхийн **ᠶᠡᠨ** - **iren - ирэн** гэдэг үгтэй дүрс ижил болохоос зайлсхийж энэ хэлбэрээр бичсэн байж болох юм. Гадаад үгийн бичлэгийг монгол үгнийхтэй дүрс ижил болгохоос аль болохоор зайлсхийдэг байсан нь бичиг зохиолоос нэлээд ажиглагдана. Ер нь гадаад хэлний үгийг монголоор буулгахдаа төрөлхи хэлний үгтэй дүрс ижил хэлбэрээр бичихгүй байхыг хичээж, гадаад үгнийх нь хэлбэрийг аль болохоор хадгална.

ᠶᠡᠨᠰᠠᠨᠢ - **Ispani - Испания - Spain**. Герман хэлэнд энэ үгийг **Espagne** хэмээн бичнэ. Монгол бичгийн хэлэнд "s" гийгүүлэгчээр эхлэсэн гадаад үгийг дуудахдаа урьд нь "т - i" эгшиг оруулж дууддаг онцлогийг энд бас харгалзсан байж болох юм. Орос, герман зэрэг хэлэнд энэ үгийн бичих байдлыг ч харгалзсан байж болох юм. Ингэж бичсэнээс болоод гадаад үгийн утга, хэлбэрт өөрчлөлт орохгүй гэдгийг анхаарч иржээ.

ᠶᠡᠨᠢᠯᠢ - **Itali - Italy**. Анх бичсэн энэ хэлбэр нь бичлэгийн хэвшсэн хэлбэр болон тогтсон байна. Монгол бичгийн хэлэнд бичлэг нь анхнаасаа хэвшсэн гадаад үг олон бий.

ᠴᠠᠸᠠᠰ - **Caucas - Кавказ - the Caucasus**. Энэхүү уулын нэрийг англиар **Caucasus**, герман, францаар **Caucase**, оросоор **Кавказ-Kavkaz** хэмээн тус тус бичнэ. Гэтэл монгол үсгээр гадаад үгийг бичиж ирсэн уламжлалаас үзэхэд олон хувилбар гараагүй бичлэг тогтож хэвшсэн байна. Харин хоёрын зэрэг тохиолдолд кирилл бичлэлийг дагуулан

буулгасан нь тааралдана. Энэ нь **author, Europa...** зэрэг үгийг шинэ үсгээр буулгахдаа **автор, Европа** хэмээн бичиж ирсэнтэй нэгэн адил юм. Ер нь англи, франц зэрэг хэлний **U u** үсгийг орос хэлний **В в** үсэгт дүйлгэн буулгадаг дүрэм ч бий. Харин төгсгөлийн "ш - s" гийгүүлэгчийн тухайд гэвэл гадаад хэлний үгийг монголоор буулгахдаа "ᠰ ᠰ - z" гийгүүлэгчийг "ᠰ ᠰ - s"- ээр сэлгэдэг дүрэмтэй. Энэ нь тухайн үсэг үгийн эхэнд орсноос бусад тохиолдолд байж болно. Жишээлбэл, капитализм - **ᠰᠢᠴᠢᠯᠢᠰᠢᠮ** - kapitalism гэх мэт.

ᠰᠢᠩᠭ᠎ᠠ - **Conggo** - **Конго** - **Congo**. Энэ үгийг **ᠰᠢᠩᠭ᠎ᠠ** - **ᠰᠢᠩᠭ᠎ᠠ** - **Conggo** - **Congyo** - **Конгго** гэж хоёр хувилбараар бичиж, харин **Конго** гэх мөрний нэрийг **ᠰᠢᠩᠭ** - **Congg** хэмээн бичиж болно хэмээн доктор Чой. Лувсанжав, Ж. Лувсандорж нар үзсэн байна. Өвөр Монголын "Шинэ үсгийн дүрмийн хадмал толь" бичигт **ᠰᠢᠩᠭ᠎ᠠ** хэмээн бичиж, **Конго** гэж галигласан байна. (Тал - 869). Энэ улс, гол хоёрын ижил нэрийг орос, англи, франц зэрэг хэлний толь бичгүүдэд **Конго, Congo, Congo** гэж бичдэг учраас түүнийг монгол үсгээр буулгахдаа **ᠰᠢᠩᠭ᠎ᠠ** - **Conggo** хэмээн бичих нь хувилбаргүй, улмаар бичлэг нэг мөр болоход сайн талтай юм. Энэ үгийн төгсгөлийн задгай үеийн талаархи дүрмийн тайлбар өмнө гарсан **ᠠᠩᠭᠣᠯᠠ** - **Angyola** хэмээх үгний тайлбартай адил юм. Зарим хэлэнд ижил нэртэй хоёр өөр зүйлийг дүрс ялган бичдэг уламжлал бас байдаг. Жишээлбэл, герман хэлэнд **Москва** хотын нэрийг **Moscou**, харин **Москва** голын нэрийг **Moscova** хэмээн өөр өөрөөр бичдэг.

ᠯᠢᠪᠢ - **Libi** - **Ливия** - **Libia(Libya)**. Энэ үгийг сүүлийн үед хэвлэгдэн гарсан толь бичгүүдэд орос хэлний эм хүйст үгийн хэлбэрийг хадгалан **ᠯᠢᠪᠢ** - **Libiy-a** хэмээн бичсэн байдаг. Гэхдээ монгол бичгийн хэлний дүрэм ёсоор **ᠯᠢᠪᠢ** - **Libi** гэж бичнэ.

ᠮᠠᠳᠠᠶᠠᠰᠠᠭᠠᠷ - **Madayaskar** - **Madagascar**. Энэ оноосон нэрийн бичлэг нэг мөр болон хэвшсэн байна. Энд гийгүүлэгч үсгүүдийн бөөгнөрөлгүй учраас бичлэгийн хувилбар гараагүй байна.

ᠮᠢᠰᠢᠷ - **Misir** - **Египет** - **Egypt**. Энэ нэрийн талаар академич Б. Ринчен тэмдэглэхдээ: "*Мисир гэж монголчууд дээр цагт одоо оросын **Египет**, Английн **Эджипт**, Азербайджан, Араб, мөн Мисирийнхэн өөрсдөө **Мисир** гэдэг газрыг нэрлэдэг байсан нь манай ард түмэн эртний соёлтой, дээр цагаас олон улстай соёл төрийн харилцаатай байсны гэрч болно. ... Манай ардын аман зохиолд **Мисир болд** гэх зэргээр гардаг байна*". (Ринчен. 1959 : 60 - 61). Хэдийгээр монголчууд дээр үеэс нааш энэ орныг **Мисир** хэмээн нэрлэж ирсэн боловч, одоо энэ нэр нэгэнт хууч үг болсон тул дэлхийн олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа нэрээр буюу **ᠶᠡᠭᠢᠯᠢᠮᠢᠰᠢᠷ** - **Yegipet** - **Египет** хэмээн монгол бичгээр буулган бичих болжээ. Харин энэ Мисир хэмээх үг зөвхөн ном зохиолд л тохиолдоно.

ᠣᠷᠤᠰ - **Orus - Русь - Russian**. Энэ нэрийг "Монгол хэлний товч тайлбар толь"-д "Дорнод Славяны ард түмний нэр" гэжээ. (Цэвэл. 1966 :424) "Монгол бичгийн хэл, халхын аялгууны харьцуулсан хэлний зүй"-д "...Монгол бичгийн хэлний **orus**, Халх аялгууны **орос** гэдэг нь **Русь, русский** хэмээх үг юм" гэжээ. (Владимирцов. 1929 : 366). Энэ **Орос** хэмээх үг монгол хэлэнд хэдий үед орсныг тогтоох боломжгүй юм. "Монголын нууц товчоо"-ны латин галигт **Orosut** (262-р зүйл) хэмээн тэмдэглэсэн байна. Чухам **Орос** хэмээн бичих болсны тухайд гэвэл монгол хэлэнд "ᠮ - ᠷ" гийгүүлэгчээр эхлэсэн үг байхгүй, одоо байгаа нь монгол хэлэнд харь хэлнээс орсон үгс юм. Тэрхүү "ᠮ - ᠷ" - ээр эхлэх үгийг монгол хүмүүн дуудахдаа хойно нь орох эгшгийг урагшлуулан тэр эгшгээр нь эхлүүлэн дууддаг байна. Жишээлбэл, **Rin-chen** (**Эрдэнэ**) хэмээх төвөд нэрийг ойрод аялгуунд ᠠᠷᠢᠨᠴᠢᠨ - **Эрэнцэн - Erencen**, франц хэлний **roi de France** (**Францын хаан танаа**) гэдгийг ᠢᠷᠠᠳᠪᠠᠷᠠᠩ - **irad Barans** (Аргун хаанаас Францын Филипп хаанд илгээсэн бичгээс) гэх мэт. Монгол бичгийн хэлэнд **Орос** хэмээн бичлэг, дуудлагын хэлбэрээр хэвшсэн **Русь** гэдэг үг нь тайлбар болон нэвтэрхий толь бичгүүдэд тэмдэглэснээр **Орос нутаг (русская земля)** гэсэн утгатай бөгөөд одоо энэ үг орос хэлэндээ хууч үг болж улмаар толь бичигт тэмдэглэгдэхээ байж, энэ язгуурт **русский, Россия...** хэлбэрт үгс болон толь бичигт орсноор **орос үндэстэн, Орос орон, Орос улс, орос хүмүүн ...** зэрэг утгаар хэрэглэгдэх болсон байна. Энэ үгийн хэлбэр нь бараг анхныхаараа **Белорус** гэх нийлмэл нэрийн нэг болон хэрэглэгдсээр байна. Энэ нь **Белая Русь** гэсэн нийлэмж үг юм. ᠪᠡᠯᠣᠷᠤᠰ - **Belorus** -

Белорусь хэмээн Маршал Чойбалсангийн илтгэл, өгүүллэгийн хоёр дугаар ботьд (424-р тал) монгол үсгээр буулган бичсэн байна. Анхлан **Русь** гэдэг үг монгол хэлэнд орсон байна. Ингээд **Русь** гэдэг үгийн "ᠮ - ᠷ" гийгүүлэгчийн арын ᠮ - ᠤ эгшиг урагшлан **Урусь** гэдэг үг болон монгол бичгийн хэлэнд орсон байна. Монгол бичгийн хэлэнд ᠣᠷᠤᠰ - **орос-oros, урус-urus** хэмээн нутаг нутагт дуудаж бичсээр ᠣᠷᠤᠰ - **о** эгшигт дуудлага нь давамгайлж, улмаар энэ дуудлага дагуу бичлэгийн уламжлал тогтсон байж болох юм. Нэгэнт энэ нь гадаад үг болох учраас бичлэг нь ч гадаад үг гэдгийг харуулах ёстой. Зүй нь энэ үгийг ᠣᠷᠤᠰ - **Orus** хэмээн монгол бичигт буулгах ёстой. Энэ мэт гадаад үг гэдэг нь тэр бүр анзаарагдахгүй болсон европын хэлний (**завод, замаг(бууны) г.м**) үгс монгол хэлэнд бий. Ийм учраас бичлэгийн уламжлалыг харгалзан ᠣᠷᠤᠰ - **Oros** хэмээн бичнэ.

ᠮᠣᠨᠭᠣᠯ - **Pranca - Франция - France**. Энэ нэрийн бичлэг нь өнөөдрийн бичиж хэвшсэнээс үгийн эхний үсгээр ялгаатай юм. Бичлэгийн эхний үед энэ үгийг хоёр уруулын шүргэх гийгүүлэгчээр бичиж байжээ. Харин энэ үеэс хойшхи сонин, сэтгүүл, ном, зохиолд уруул, шүдний шүргэх гийгүүлэгчээр эхлэсэн бичгийн хэлбэр уламжлал болон тогтсон байна. Энэ **ᠮᠣᠨᠭᠣᠯ** - **Franca - Франция - France** хувилбарыг монгол бичигт мөрдөж байна. Энэ хоёр үсгийн талаар академич Б. Я. Владимирцов тэмдэглэхдээ: "Монгол бичгийн хэл, халх аялгууны аль алинд нь уруулын хамжих **n - p** гийгүүлэгч зөвхөн зээлбэр үгэнд л ордог. Хуучин монгол бичигт энэхүү авиа ерөөсөө байдаггүй, харин энэ үсэг бүхүй

зээлбэр үгийг бичих тохиолдолд **б - b** авиагаар бичдэг байсан юм. Ингээд монгол шинэ цагаан толгой шинээр хоёр үсэг нэмж авсан. Энэ бол **ᠮ** - **p**, **ᠮᠤ** - **h** хоёр бөгөөд гол төлөв **төвөд, энэтхэг** зэрэг харь хэлний үгийг галиглахад хэрэглэж байв. Жишээлбэл, хятад хэлний **пу - цзы** гэдэг үгийг **ᠮᠤ** - **fuse**, орос хэлний **фабрика** гэдгийг **ᠮᠤᠪᠢᠷᠢᠬᠠ** - **fabrika** хэмээн бичих болов" гэжээ. (Владимирцов. 1929 : 78, 407.).

Энэ хоёр үсгийн талаар академич Б. Ринчен: "Монгол хэлний үгэнд **па - фа** хоёроос ганц **па** үсэг л байж, **фа** нь тэр **па** - гийн нэгэн хувилбар бөгөөд ... хуучин бичээч нар **п-ф** хоёрыг ялгадаггүй, гагцхүү манж, нангиад бичигтэй сэхээтэн л нарийн ялгадаг байжээ. Латин үсэг хэрэглэдэг дэлхий дахины шинжлэлийн бичиг зохиолоос иш татах зэрэг зүйлд сүүлийн үеэс тэдгээр гадаадын хэл бичиг мэддэг хүмүүс дуудлага нь **ф** боловч, латин үсгээр грек гаралтай тийм нэрийн зүйлийг орос улс латин үсгээр цөм **ph** гэж бичиж байсан газры нь монгол үсгээр мөн тэрхүү **ᠮ-ᠬ** хоёры нь **ᠮᠤ** гэж галиглан бичиж байсан байна" (Ринчен. 1966 : 64).

Энэ бүхнээс дүгнэлт хийж үзэхэд латин, герег гаралтай үг ороогүй хэл европод байхгүй тул, энэ **п, ф** хоёр үсэг ороогүй цагаан толгойтой орон гэж бас байхгүй учраас европын хэлний үгийг монголоор үсэгчлэн буулгахдаа **п-д** нь **ᠮ** - г оноож, **ф-** д нь **ᠮᠤ** - г оноож буулгах болжээ.

ᠮᠤᠯᠰᠠ - **Polsha** - **Польша** - **Poland**. Энэхүү нэрийг орос нэрээс, заримдаа англи зэрэг нэрээс монгол үсгээр буулган бичиж байсан байна. Жишээлбэл, "Франц ба Европ газрын олон улсын түүх"- ийн 1-р дэвтэрт **ᠮᠤᠯᠢᠶᠠᠭ** - **Foliyag** - **Фолияг** - **Поляк** - **Pole**, мөн зохиолын 2-р дэвтэрт **ᠮᠤᠯᠤᠨ** - **Folon** - **фолон** - **poland**, "Монгол үсгийн дүрмийн толь бичиг"- т **ᠮᠤᠯᠰᠠ** - **Polsha** - **Польш** - **Poland** (Шагж. 1927:906), Өвөр Монголын "Шинэ үсгийн дүрмийн хадмал толь" бичигт англи нэрийн бичлэг дагуу **ᠮᠤᠯᠤᠨ** - **Poland** - **Поланд** - **Польша** - **Poland** хэмээн бичсэн байна. Зарим үгийн бичлэг жигдрэхгүй олон хувилбартай явсаар сүүлдээ нэг мөр болох үзэгдэл байдгийг энэ жишээ харуулж байна. Гадаад үгийг монгол үсгээр бичиж эхэлж байсан үед **ᠮᠤᠯᠤᠨ** - **f, p** хоёр гийгүүлэгчийг төдий л ялгахгүйгээр бичиж ирсэн байна. Одоо энэ нэрийг орос хэлний нэрийн хувилбараас орсон **ᠮᠤᠯᠰᠠ** - **Polsha** хэлбэрээр бичиж байна.

ᠮᠤᠯᠤᠨ - **Portuyal** - **Португалия** - **Portugal**. Энэ орон газар зүйн байрлалаараа манай орноос алс оршиж, холбоо харилцаатай байгаагүй учир эхэн үеийн ном зохиолд төдий л их гардаггүй, цөөн тааралддаг нэр юм. Жишээлбэл, "Арван таван наст капитан" зохиолд орчуулагч **ᠮᠤᠯᠤᠨ** - **Portuyal** - **Португалия** - **Portugal** хэмээн монгол үсгээр буулган бичсэн байдаг. Эндээс үзэхэд тухайн үед европын хэлний үгийг монгол үсгээр буулгахдаа **о, у** - **о, у** хоёр эгшгийн ялгааг гаргаж бичдэггүй байсныг харуулж байна. Иймэрхүү жишээ тухайн үеийн орчуулгын ном, зохиолд олонтаа тааралддаг. Нэрийн бичлэгийн уламжлал болсон хэлбэр нь анхныхтайгаа төслүү бөгөөд гагцхүү **у** - **у** эгшгийг гадаад үгэнд бичдэг хэлбэрээр **ᠮᠤᠯᠤᠨ** - **Portuyal** - **Португал** - **Португалия** - **Portugal** хэмээн бичнэ.

ᠷᠤᠮᠠᠨᠢ - **Rumani** - Румыния - **Romanian**. Энэ нэрийг "Франц ба Европ газрын олон улсын түүх"- д **ᠷᠣᠮᠠᠨᠢ** - **Roman...**, "Үсгийн дүрмийн толь бичиг"- т **ᠷᠣᠮᠠᠨᠢ** - **Rumani**, "Эв хамт намын түүх"- д **ᠷᠣᠮᠠᠨᠢ** - **Rumini**, "Үгийн утга, учир"- т мөн **ᠷᠣᠮᠠᠨᠢ** - **Rumini**, энэ хувилбар "Монгол бичиг - 8" сурах бичигт бас байна. Өвөр Монголын "Шинэ үсгийн дүрмийн хадмал толь" бичигт **ᠷᠣᠮᠠᠨᠢ** ᠷ - **Romania** гэсэн хувилбараар бичсэн нь англи нэрийг үсэгчлэн буулгажээ. Монгол бичигт нэг мөр болгон бичиж байгаа хэлбэр бол **ᠷᠣᠮᠠᠨᠢ** - **Rumin** юм.

ᠰᠤᠮᠠᠲᠤᠷ - ᠷ - **Sumatra** - Суматра - **Sumatra**. Энэхүү арлын нэр монгол нэртэй ойролцоо учир нүдлэж бичихэд амархан тул төгсгөлийн **а - а** эгшгийг өмнөх дараалсан хоёр гийгүүлэгчийн хооронд жийрэглэж **ᠰᠤᠮᠠᠲᠤᠷ** - **Sumatar** - Суматар хэмээн бичих болсон байна.

ᠲᠤᠪᠠ - **Tuva** - Тува - **Tuva**. Нэрийг бичих байдал анхнаасаа монгол бичигт нэг мөр болон тогтсон учир бичлэгийн хувилбар гараагүй байна.

ᠲᠥᠪᠡᠳ - **Töbed** - Тибет - **Tibet**. Харин орос тайлбар толь бичигт тэмдэглэснээр бол тэд өөрсдийгөө **пёба** хэмээн нэрлэдэг гэнэ. Энэ нэр монгол хэлэнд орохдоо **и** эгшиг **ө(ү)** эгшгээр, **т** гийгүүлэгч **д** гийгүүлэгчээр тус тус сэлгэжээ. Ийнхүү **ᠲᠥᠪᠡᠳ** - **Töbed** хэмээн бичсэнээр ойрад аялгуутан **ᠲᠥᠪᠡᠳ** - **Tübed** - **Түбэд**, халх аялгуутан **ᠲᠥᠪᠡᠳ** - **Töbed** - **Төвэд** хэмээн тэрхүү полифоныг өөр өөрийнхөөрөө дуудаж, адилхан дүрсээр бичдэг нь энэ бичгийн бас нэг гайхамшиг юм.

ᠲᠦᠭᠦᠭ - **Tügüg** - Турция - **Turkey**. "Орос-монгол толь бичиг, Монгол-орос толь бичиг" зэрэгт шинэ үсгээр **Турк** хэмээн бичиж, оросоор **Турция** хэмээнэ гэжээ. "Англи-орос толь бичиг"-т **Turkey** гээд оросоор **Турция** гэсэн байна. Харин "Орос-франц толь бичиг"-т **Турция** гээд францаар **Turkuie** хэмээн тус тус тэмдэглэсэн байна. Мөн "Зөвлөлтийн нэвтэрхий толь бичиг"-т "**Турки** (Тэд өөрсдийгөө **тюркүүд** гэнэ.) гэдгийг "**үндэстэн, Турк улсын үндсэн хүмүүн ам**" юм гэжээ. Энэ үгийг монгол үсгээр буулгасан тухайд гэвэл "Монгол үсгийн дүрмийн толь бичиг"- т **ᠲᠦᠭᠦᠭ** - **Tügüg** - **Түүгүг**, VIII ангийн монгол бичгийн сурах бичигт **ᠲᠦᠷᠦᠭ** - **Türk** - **Түрк**, "Эв Хамт Намын Түүх"- д **ᠲᠦᠭᠦᠭ** - **Tügüg** - Турция, Өвөр монгол тольд **ᠲᠦᠷᠦᠭ** - **Türka** хэмээн тус тус бичиж ирсэн уламжлал байна. Академич Б. Ринчений тэмдэглэснээр: "Монгол бичгээр **ᠲᠦᠷᠦᠭ**, кирилээр буулгавал **тюрюг** буюу одооны дуудлагаар бол **түрүг**, одооны бичих "дүрэмд" ү-гийн дараагаар ү бичихгүй э бичнэ гэдгээр бол **түрэг** гэж бичих нэгэн зүйл угсаатны нэр, эртний түрэг хэлээр бол **тюрк**, латинаар галиглавал **türk** гэдэг үг, монгол хэлнээ хоёр гийгүүлэгч зэргэцэн ордоггүй **авиан** зүйн журмаар **түрк** гэдэг нь **түрүг-түрэг** болж ирсэн байна... (Ринчен. 1966 : 234). Судалгааны хэрэглэгдэхүүнээс үзэхэд энэ нэрийг хамгийн анхных нь хувилбараар бичих нь зүйтэй юм.

ᠬᠢᠷᠭᠢᠰ - **Kirgis** - Киргизия - Kirgizia. Академич Б. Ринчений үзэж байгаагаар бол энэ үгийг монголын дээд эртний буюу дундад эртний **ᠬᠢᠷᠭᠢᠰ** - **qiryis**, шинэ цагийн монгол бичгийн **ᠬᠢᠷᠭᠢᠰ**, аман хэлний **хиргис**, орчин үеийн орос хэлнээ **киргиз** гэдэг нь цөм нэг юм... хэмээжээ. (Ринчен. 1966 : 182). 1950 -аад оны эхин үеийн нийгэм улс төрийн ном зохиолд энэ үг **ᠬᠢᠷᠭᠢᠰ** - **Kirgis** гэдэг хэлбэрээр тааралдана. Өнөөдөр бидний шинэ үсгээр "Хяргас" хэмээн бичдэг үг бол Увс аймгийн нэгэн баяд сумын нэр, мөн Монголын нэгэн томоохон нуур болох "Хяргас" зэрэг нэрийг монгол үсгээр **ᠬᠢᠷᠭᠢᠰ** - **Kirgis** хэмээн бичдэг уламжлалтай юм. Ийм учраас энэ үг монгол бичгийн хэлэнд байгаа болохоор бичлэгт зөрүү гарахгүй байна.

ᠬᠢᠲᠠᠳ - **Kitad** - Китай - China. Оросын газар зүйч эрдэмтэн Э. М. Мурзаевын тэмдэглэснээр: "Китай хэмээх нэр нь анх Орос газарт дундад зууны үед Хойт Хятадыг байлдан дагуулж эзлэсэн Төв болон Дорнод Азийн **Кидан** гэдэг гүрэн улсын нэрээр дамжиж орсон юм. Италийн жуулчин Марко Пологийн тэмдэглэлд **Катай** гэдэг нэрээр орсон байна. Хятадууд өөрсдөө Чжунго буюу Дундад улс хэмээн нэрлэнэ. Европын хэлүүдэд **China** гэдэг хэлбэрээр орсон. Энэ нь **Цинь** овогтны угсаа залгамжлалын үеийн нэрээр ийнхүү нэрлэх болсон юм" гэжээ. (Мурзаев. 1979 : 161). "Зөвлөлтийн нэвтэрхий толь бичиг"- т "**Кидани (Kитай)** бол эрт дээр үед одоогийн Өвөр Монгол (БНХАУ) ба БНМАУ-ын нутгаар нүүдэллэн суудаг байсан монгол овгийн аймгууд юм" гэжээ. (СЭС. 1985 : 575).

Орос хэлээр гарсан ном, зохиолд **Кидан**, **Китай** гэдэг нь угтаа нэг зүйл хэмээн ойлгогдохоор гардаг. Мөн 1966 онд хэвлэгдсэн "БНМАУ - ын түүх"- д мөн "**кидан**" гэж бичсэн байдаг. Харин монгол үсэг, бичиг судлаач эрдэмтэн Ц. Шагдарсүрэн, Д. Кара нарын бүтээлд "**хятан**" хэмээн гардаг. Яаж бичсэн ч гэсэн монгол бичгийн хэлэнд орос хэлээр дамжиж "**китай**" гэдэг үг орсон нь маргаангүй, тэр **ᠬᠢᠲᠠᠳ** - **Kitay** гэдэг үгэнд ястан, үндэстний олны утгатай **ᠬᠢ** - **d** дагавар залгаж улмаар өнөөдөр бидний бичиж байгаа **ᠬᠢᠲᠠᠳ** - **Kitad** - **Хятад** гэдэг нэр үүссэн байх гэж таамаглаж байна.

ᠶᠡᠷᠣᠭᠤᠯᠠ - **Europa** - Европа - Europa. Харин **Europa** гэдэг үгийг **F'oiropet** хэмээн бичих бөгөөд ингэж бичихийн учир гэвэл үгийн эхэнд хоёр богино эгшиг орж байгаа учраас тэр хоёрыг бие биенээс нь тусгаарлахын тулд халхавч **ᠶ** - **v** үсгийг хэрэглэнэ. Энэ үгийг Ц. Жамцарано **ᠶᠡᠷᠣᠭᠤᠯᠠ** - **Ibrofa** - **Иброфа** хэмээн бичжээ. Хэдийгээр энэ үгийг хэд хэдэн янзаар бичиж ирсэн ч гэсэн англи, франц зэрэг хэлний үгийн бичлэгийг баримтлан буулгаж ирсэн хэлбэрээр бичлэг нь хэвшиж нэг мөр болсон байна.

ᠶᠡᠨᠢᠳᠢᠶ᠋ᠠ - **Enedkeg** - Индия - India. Энэ үгийг монгол хүмүүн гадаад үг гэхээсээ илүү монгол үг хэмээн хэлж болох талтай. Учир нь монгол хэлний эгшиг зохицох ёс энэ үгэн дээр тод харагдана. Гэтэл энэ нь европын хэлнээс монгол бичгийн хэлэнд дээрхи байдлаар орж

хэвшсэн үг юм. Энэ үгийг англи хэлэнд **India** - **ᠶᠡᠨᠳᠢᠶ᠋ᠠ** ᠶ · францаар **Inde** - **ᠶᠡᠨᠳᠡ** · оросоор **Индия** - **ᠶᠡᠨᠳᠢᠶ᠋ᠠ** ᠶ хэмээн тус тус бичнэ. Бид энэ үгийг монгол бичгийн хэлэнд европын хэлээр дамжиж орсон гэдэгт эргэлзэхгүй байна. Энэ нэрийн монгол орчуулга нь **Жагар** хэмээх үг юм. Тользүйч эрдэмтэн Я. Цэвэл үзэхдээ: "Жагар. Энэтхэг, цагаан хятад. Монгол бичгээр **ᠵᠠᠶᠠᠷ ᠵᠠᠵᠠᠷ** - *Jayar, Jakar*" хэмээнэ гэжээ. (Цэвэл. 1966 : 881). Энэ үг одоо хэр баруун монголчуудын дунд хэрэглэгдсээр байгаа үг юм. Тэд Жагарын орон, Жагар газар хэмээн хэлэлцдэг юм. Доктор О. Сүхбаатар энэ үгийн гарлын талаар тэмдэглэхдээ: "*Энэтхэг согд. Yntkk<yi. Enätkäk> мо. б. enetkeg; Самгарди хэлний Sindhi мөрний нэрээс үүсэлтэй, персчүүд Hindhu гэж дуудаж, согдууд энэткэк гэх болжээ.*"(1999 : 267).

Бидний үзэж байгаагаар бол европын хэлний үгийн эхний и эгшиг нь монгол бичгийн хэлний **э** эгшгээр, дараалсан хоёр гийгүүлэгчийн хооронд эхнийхтэй ижил **э** эгшиг жийрэглэсэн, **д** гийгүүлэгч **т** гийгүүлэгчээр сэлгэсэн байна. Монгол хэлэнд энэ үг эхлээд Индийн хойг гэсэн нийлэмж үг байснаа тэр хойгийн **ой** хэмээх хос эгшиг нь өмнөх үеийнхээ эгшигтэй урагшлан ижилсэх замаар **хойг** нь **хэг** болон нийлмэл үг болж, улмаар Энэтхэг гэдэг улсын нэр болсон байх гэж таамаглаж байна. Ер нь **хойг** хэмээх үг бол аливаа зүйл, юмын байр, орныг заасан утгатай үг. Энэ талаас нь үзсэн ч **Энэтхэг**, **Индостан** хоёр утгын хувьд ижил тул монгол хэлний **-хэг**, гадаад хэлний **-стан** хэмээх хоёр утгат хэсгийг нэг утгатай гэж үзэж болох талтай юм.

ᠶᠡᠨᠢᠮᠤᠯᠠ - **Etiyopi** - **Эфиопия** - **Ethiopia**. Энэ нэр VIII ангийн монгол бичгийн сурах бичигт **ᠶᠡᠨᠢᠮᠤᠯᠠ** -**Etiofi**, Өвөрмонголын "Шинэ үсгийн дүрмийн хадмал толь"-д **ᠶᠡᠨᠢᠮᠤᠯᠠ** ᠶ -**Ejiopiy-a** хэмээн тус тус бичсэн байна. Энэ үгийг монгол бичгээр 1920-иод оноос дээрхи хэлбэрээр бичиж байгаад 1980-аад оноос Эфиопи хэмээн орос хэлний толь бичигт тэмдэглэн бичсэнээр бичих болсон байна. Англи хэлний **Thomas** гэхийг шинэ үсгээр буулгавал **ᠲᠣᠮᠠᠰ** - **Томас** гэнэ. Харин франц хэлний **Thomas** хэмээх нэрийг оросоор **Тома** эсвэл **Фома** гэсэн нь энэхүү нийлмэл үсгийг "4 - t" гийгүүлэгчээр буулгахаас гадна "ᠹ - t" гийгүүлэгчээр буулгаж болохыг харуулж байна. Орос хүмүүний нэрийн зүйлийн толь бичигт тэмдэглэснээр **Тома**, **Томик** гэх нэртэй нэг язгуур бүхий нэр нь **Артоном**, **Артамон**, **Том**, **Фома** зэрэг эрэгтэй, **Тамара**, **Томила** гэх эмэгтэй хүмүүний нэр болох ажээ. Харин одоо энэ үгийг монгол үсгээр **ᠶᠡᠨᠢᠮᠤᠯᠠ** - **Etiofi** - **Этиофи** хэмээн бичих болсон байна.

Уйгуржин хэмээх тодотголт үсэг бичгийг монголчууд хэрэглэх болсноор улс орныхоо амьдрал, түүх, гол гол үйл явдлыг тэмдэглэн хойч үедээ үлдээх зорилгоор хэрэглэж байсан төдийгүй түүнийг монгол төрийн бичгийн хувьд улс хоорондын дипломат харилцаанд өргөн хэрэглэж ирсний нэг жишээ бол 1289 онд Ил-хаан Аргуны францын Гоо Филипп дөрөвдүгээр ванд илгээсэн захидал юм. Уг захидалд франц хэлний "**goi de Fransa**" гэсэн нийлэмж үгийг монгол бичгээр бичсэн болон бусад гадаад үгс (**Мисир**, **Орислим**, **франкууд**) –ийг монгол үсгээр бичсэн байдаг. Энд бичсэн гадаад үгэнд монгол хэлний зохих дагаваруудыг

хэрэглэсэн байна. Мөн иймэрхүү агуулгатай өөр нэг бичиг бол 1302 онд Ил хаан Хасанаас католик шашны пап Бонифаст илгээсэн бичиг юм. Энэ бичгийн дотор "**пап, султан**" зэрэг гадаад үг орсон ба тэдгээрийг хэлзүйн тодорхой хэлбэрт (өгөх оршихын тийн ялгал, олон тооны нөхцөл) оруулж хэрэглэсэн байна. Эдгээр гадаад хэлний үгсийг монгол үсгээр анхлан буулгасан гадаад(европын хэлний) үгс хэмээн үзэж (Н.Б.) болох юм.

Аливаа нэг бичгийн хэлээр гадаад хэлний үгийг дамжуулан уншигчдад хүргэдэг үндсэн гурван арга байдаг хэмээн ерөнхий хэлний шинжлэл үздэг. Үүнд: **Нэгд**, гадаад үгийг авиачлан буулгах; **Хоёрт**, гадаад үгийг үсэгчлэн буулгах; **Гуравт**, гадаад үгийг гадаад хэлнийх нь үсэг бичгээр буулгаж, бууж байгаа хэлний зүйгээр дагаваржуулан хэрэглэх гэх мэт. Харин нийт олны мэддэг өргөн хэрэглээний гадаад үгийг олон нэмэлт үсэг, тэмдэгт хэрэглэлгүйгээр тухайн хэлний цагаан толгойн үсгээр гол болгон уншигч олон саадгүй ойлголцож байхад зориулан хялбарчлан бичдэг учир гадаад хэлний авиа бүрийг байгаагаар нь буулгах шаардлагагүй байдаг. Гадаад хэлний үгийг төрөлхи хэлний үсгээр ингэж бичихийг өргөн хэрэглээний зорилгоор бичих хэмээн үзнэ. Гадаад хэлний үгийг бичихдээ бууж байгаа болон буулгаж байгаа хэлүүдийн авиа зүй, үг зүйн нийтлэг зарчмыг баримтлахын зэрэгцээ уламжлалт бичлэгийг харгалзах нь зүйн хэрэг.

Хэрэглээний зорилгоор гадаад үгийг бичихдээ: **Нэгдүгээрт**, тухайн гадаад хэлний үгийн бичлэг, дуудлагад ойр бичих; **Хоёрдугаарт**, гадаад үгийн хэлбэрийг аль болохоор хадгалах; **Гуравдугаарт**, үгийн утгыг алдагдуулахгүй байх; **Дөрөвдүгээрт**, төрөлхи хэлний үгтэй бичлэг адил болгохгүй байх; **Тавдугаарт**, тухайн үгийг дахин сэргээн бичих боломжтой байлгах; **Зургаадугаарт**, гадаад үг гэдэг нь танигдахаар байх; **Долоодугаарт**, гадаад үг бууж байгаа хэлний хэлзүйн дүрмээр дүрэмжин хэрэглэгдэх гэх мэт шаардлагыг хангаж бичнэ.

Ер нь гадаад хэлний үгийг **авиа зүй, үсэг зүй, хэл зүй, утга зүйн** талаас нь анхааран тухайн хэлний хэлний үндсэн үгийн хэмжээнд хэрэглэнэ. Монгол үсгээр европын хэлний үгийг бичиж ирсэн уламжлал, туршлага нь орчин цагийн монгол бичгийн хэлний авиан зүй, үг зүйн нийтлэг зарчимд тулгуурласан болохоор олон жилийн шалгалт сорилтыг давж өнөөдрийг хүрч ирсэн байна.

1587 онд Аюуш гүүшийн зохиосон галиг үсгийн тогтолцоо, 1741-1742 онуудад Жанжаа хутагт Ролбийдоржийн удирдлагаар монгол олон эрдэмтэний зохиосон "**Мэргэд гарахын орон**" хэмээх төвөд-монгол нэр томъёоны толь бичиг зэрэг нь монгол үсэг бичгээр дэлхийн олон хэлний нэрийн зүйлийг нэвтрүүлэн буулгах бололцоог нээж өгсөн юм. Энэ талаар академич Б. Ринчен тэмдэглэхдээ: "*...Монгол цагаан толгойн хорин долоон үсэг латин, герег цагаан толгойд байдаг үсэг, латин үсгээр өөр өөрийн үндэсний үсэг хийсэн англи, герман, франц зэрэг европын бүх олон улсын үсгийг цөмийг нэг ч үсэг дутагдахгүйгээр тэмдэглэх үсэг ажээ*" гэсэн байна. (Ринчен. 1966 :66).

Энд бичсэн зүйл ч гэсэн эрдэмтний хэлсэн энэ мэргэн үгийг зарим талаар батлах болов уу.

Ном зүй

I. Кирилл үсгээр

1. Владимирцов Б. Я, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия*, Ленинград, 1929.
3. Ринчен Б, *Монгол бичгийн хэлний зүй*, Дэд дэвтэр, Авиан зүй, Улаанбаатар, 1966.
4. Шагдарсүрэн Ц, *Монгол үсэг зүй*, Тэргүүн дэвтэр, Улаанбаатар, 1981.

II. Монгол үсгээр

1. Eren Gustab, *Faranca ba lbropna yajar-un olan ulus-un te üke*, Ulaanbayatur, 1927.
2. Caun Lion, *Köke Mongyul-un Köke tuy kemekü te üke*, Ulaanbayatur, 1925.
3. Luvsangvangdang Š, *Mongyul kelen-ü züу*, Ulaanbayatur, 1929.
4. Luvsangjav Čoy, Luvsangdorji J, *Mongyul bi čig*, VIII Anggi, Ulaanbayatur, 1987.
5. *Mongyul-un ni yu ča tob čyan*, Ulaanbayatur, 1947.
6. *Nam-un arban niged üger yeke qural-un iledgel, toyta yal*, Ulaanbayatur, 1948.
7. *Nam-un dörbed üger yeke qural*, Ulaanbayatur, 1931.
8. Rinchin B, *Üge-yin udqa u čir*, Öbörmongyul-un arad-un keblel-ün qoriy-a, 1950.
9. Čoyibalsang Qo, *iledgel ba ög ülel-n ügüd*, Dүger – I, Ulaanbayatur, 1951.

III. Толь бичиг /кирилл үсгээр/

1. Балжинням Н, *Монгол хэлэн дэх Европын хэлний үгийн монгол бичгийн толь*, УБ. 2002.
2. *Монгол- орос толь*, Москва, 1957.
3. *Русско-английский словарь*, Москва, 1962.
4. *Русско-немецкий словарь*, Москва, 1951.
5. *Словарь иностранных слов*, Москва, 1980.
6. Сүхбаатар О, *Монгол хэлний харь үгийн толь*, Улаанбаатар, 1990.

IV. Толь бичиг /Монгол үсгээр/

1. Luvsangjav Choy, *Yangtoytaqu yo, Borjigin Darmabala, Mongyol bi čig-ün qadamal toli*, Ulaanbayatur, 1992.
2. Cevele Ya, *Mongyul kelen-ü tob čı tayilburi toli*, Ulaanbayatur, 1966.
3. Šayja S, *Mongyul üsüg-ün dүrim-ün toli bi čig*, Ulaanbayatur, 1927.

V. Сонин, сэтгүүл /монгол үсгээр/

1. *Neyislel-ün sin-e sonin*, Ulaanbayatur, №1, 2 (1923), №8 (1934).
2. *Mongyul-un үnen sonin*, Ulaanbayatur, № 1,3, 6 (1920 –1921).
3. *Neyislel küriyen-ü sonin bi čig*, Ulaanbayatur, 1915 –1920. *Neyislel-ün sin-e sonin*, Ulaanbayatur, №1, 2 (1923), №8 (1934).
4. *Sin-e toli kemek ü sedkül bi čig*, Ulaanbayatur, 1925.

